


ТӨРИЙН БАЙГУУЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ 2015

МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН



IRIM Судалгааны хүрээлэн

Улаанбаатар

2015 он

АГУУЛГА

БАЙГУУЛЛАГЫН ТОВЧИЛСОН НЭРС	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	5
ДҮРСИЙН ЖАГСААЛТ	6
БҮЛЭГ 1. МОНИТОРИНГИЙН АРГА ЗҮЙ	7
1.1 МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ	7
1.2 МОНИТОРИНГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ЦАГ ХУГАЦАА	7
1.3 МОНИТОРИНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	7
БҮЛЭГ 2. ГОЛ ҮР ДҮН	10
2.1 Нэгдсэн үр дүн	10
1.1.1 Мэдээллийн хамааралтай байдал	10
1.1.2 Мэдээллийн найдвартай байдал	10
1.1.3 Мэдээллийн цаг үеийн байдал	11
1.1.4 Мэдээллийн хүртээмжтэй байдал	11
1.1.5 Цахим хуудсыг хэрэглэхэд хялбар байдал	12
2.2 ЯАМДЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ҮЗҮҮЛЭЛТ	13
2.2.1 Үйл ажиллагааны ил тод байдал	14
2.2.2 Хүний нөөцийн ил тод байдал	14
2.2.3 Төсөв санхүүгийн ил тод байдал	15
2.2.4 Худалдан авах ажиллагааны ил тод байдал	15
2.3 ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГУУДЫН ЦАХИМ ХУУДСЫН ҮЗҮҮЛЭЛТ	16
2.3.1 Үйл ажиллагааны ил тод байдал	16
2.3.2 Хүний нөөцийн ил тод байдал	17
2.3.3 Төсөв санхүүгийн ил тод байдал	18
2.3.4 Худалдан авах ажиллагааны ил тод байдал	18
2.4 УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРГАА, ДҮҮРГҮҮДИЙН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ	19
2.4.1 Үйл ажиллагааны ил тод байдал	20
2.4.2 Хүний нөөцийн ил тод байдал	20
2.4.3 Төсөв санхүүгийн ил тод байдал	21
2.4.4 Худалдан авах ажиллагааны ил тод байдал	21
2.5 ПАРЛАМЕНТИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ЦАХИМ ХУУДСЫН ҮЗҮҮЛЭЛТ	22
2.5.1 Үйл ажиллагааны ил тод байдал	22
2.5.2 Хүний нөөцийн ил тод байдал.	23

2.5.3	Төсөв санхүүгийн ил тод байдал	23
2.5.4	Худалдан авах ажиллагааны ил тод байдал	24
2.6	ТӨРИЙН ӨМЧИТ БАЙГУУЛЛАГУУДЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ҮЗҮҮЛЭЛТ	25
	ХАВСРАЛТ 1. ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД	28
	ХАВСРАЛТ 2. АРГА ЗҮЙН ТАЙЛБАР	29
	ХАВСРАЛТ 3. СУДАЛГААНД ХАМРУУЛСАН ЦАХИМ ХУУДСУУД	31

БАЙГУУЛЛАГЫН ТОВЧИЛСОН НЭРС

Монгол Улсын яам

БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
БХЯ	Батлан хамгаалах яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
СЯ	Сангийн яам
ХАХНХЯ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
ХЗЯ	Хууль зүйн яам
ҮХААЯ	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЗТЯ	Зам, тээврийн яам
ХЯ	Хөдөлмөрийн яам
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам
УУЯ	Уул уурхайн яам
ССАЖЯ	Соёл, спорт, аялал жуулчлалын яам

Хэрэгжүүлэгч агентлаг

АМГ	Ашигт малтмалын газар
АЕГ	Архивын ерөнхий газар
ГТГ	Газрын тосны газар
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ИХШХЕГ	Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар
ХОГ	Хөрөнгө оруулалтын газар
ГХГЗЗГ	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
МЭҮГ	Мал эмнэлэг, үржлийн газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ОӨГ	Оюуны өмчийн газар
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ТЕГ	Татварын ерөнхий газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
НХҮЕГ	Нийгмийн халамж үйлчилгээний

ерөнхий газар

ХТҮГ	Хүүхдийн төлөө үндэсний газар
ЦУОШГ	Цаг уур, орчны шинжилгээний газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар

Тохируулагч агентлаг

МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
СХЗГ	Стандартчилал, хэмжил зүйн газар
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЦЭГ	Цөмийн энергийн газар
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар
МТШХХГ	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар
ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб

Парламентийн харьяа байгууллагууд

ТАЗ	Төрийн Албаны Зөвлөл
АТГ	Авлигатай Тэмцэх Газар
СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо
СЕХ	Сонгуулийн Ерөнхий Хороо
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
УИХ	Монгол Улсын Их Хурал

Улаанбаатар хотын засаг захиргаа

НЗДТГ	Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар
-------	--------------------------------------

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Тухайн үзүүлэлтийг хангаж буй түвшин	8
Хүснэгт 2. Яамдын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт(хувь)	13
Хүснэгт 3. Агентлагуудын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт (хувь)	16
Хүснэгт 4. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн цахим хуудасны ил тод байдал (хувь)	19
Хүснэгт 5. Парламентын харьяа байгууллагын цахим хуудасны ил тод байдлын үнэлгээ (хувь)	22
Хүснэгт 6. Мониторингийн шалгуур үзүүлэлтүүд	29
Хүснэгт 7. Тухайн шалгуурыг ямар хэмжээнд хангаж байгааг үнэлэх үнэлгээ	30
Хүснэгт 8. 2015 оны мониторингийн аргазүйд нэмж оруулсан шалгуур үзүүлэлтүүд	30

ДҮРСИЙН ЖАГСААЛТ

Дүрс 1. Шалгуур үзүүлэлт тус бүрийн үнэлгээний системд эзлэх хувь	8
Дүрс 2. Шалгуур үзүүлэлт тус бүрийн үнэлгээний системд эзлэх хувь	10
Дүрс 3. Төрийн байгууллагын мэдээллийн хамааралтай байдал	10
Дүрс 4. Төрийн байгууллагын мэдээллийн найдвартай байдал	10
Дүрс 5. Төрийн байгууллагын мэдээллийн цаг үеийн байдал	11
Дүрс 6. Төрийн байгууллагын мэдээллийн хүртээмжтэй байдал	11
Дүрс 7. Төрийн байгууллагын цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдал	12
Дүрс 8. Яамдын цахим хуудасны ил тод байдал (хувь)	13
Дүрс 9. Яамдын ерөнхий мэдээлэл (хувь)	14
Дүрс 10. Яамдын хүний нөөцийн ил тод байдал (хувь)	14
Дүрс 11. Яамдын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)	15
Дүрс 12. Яамдын ХАА-ны ил тод байдал (хувь)	15
Дүрс 13. Агентлагуудын цахим хуудасны ил тод байдал (хувь)	16
Дүрс 14. Агентлагуудын ерөнхий мэдээлэл (хувь)	17
Дүрс 15. Агентлагуудын хүний нөөцийн ил тод байдал (хувь)	17
Дүрс 16. Агентлагуудын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)	18
Дүрс 17. Агентлагын ХАА-ны ил тод байдал (хувь)	18
Дүрс 18. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн цахим хуудасны ил тод байдал (хувь)	19
Дүрс 19. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн ерөнхий үзүүлэлт (хувь)	20
Дүрс 20. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн хүний нөөцийн ил тод байдал (хувь)	20
Дүрс 21. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)	21
Дүрс 22. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн ХАА-ны ил тод байдал (хувь)	21
Дүрс 23. Парламентын харьяа байгууллагуудын ил тод байдлын үнэлгээ(хувь)	22
Дүрс 24. Парламентын харьяа байгууллагуудын ерөнхий мэдээллийн үнэлгээ (хувь)	22

Дүрс 25. Парламентын харьяа байгууллагуудын хүний нөөцийн ил тод байдал(хувь)	23
Дүрс 26. ХАА-ны ил тод байдал (хувь)	24

БҮЛЭГ 1. МОНИТОРИНГИЙН АРГА ЗҮЙ

1.1 МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Энэ судалгаа нь төрийн болон төрийн өмчит байгууллагуудын цахим хуудаст мониторинг хийж “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль” болон “Шилэн дансны тухай хууль”-н хэрэгжилтийг үнэлэх, цаашдын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах талаар санал зөвлөмж боловсруулах зорилготой.

Энэ хүрээнд доорх зорилтууд тавьсан:

- Төрийн захиргааны байгууллагуудын цахим хуудсыг “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-д тусгагдсан 4-н үндсэн шалгуур үзүүлэлт болох үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал тус бүрээр үнэлэх,
- Ингэхдээ төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийг “Шилэн дансны тухай хууль”-ийн заалтуудыг баримтлан хэрэгжилтийг үнэлэх
- Төрийн өмчит байгууллагуудын цахим хуудсанд зөвхөн “шилэн дансны тухай хууль”-д заагдсан шалгуур үзүүлэлтээр мониторинг хийх;
- Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагын цахим хуудсыг ил тод байдлын үзүүлэлтээр нь эрэмбэлж, төрөл тус бүрээр нь жагсаалт гаргах;
- Цахим хуудаст тавигдсан мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн санал зөвлөмж боловсруулах.

1.2 МОНИТОРИНГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ЦАГ ХУГАЦАА

Мониторингийн мэдээллийг 2015 оны 12 сарын 02-оос 12 дугаар сарын 17-нд хийсэн ба энэ хугацаанд ажиллаж байсан нийт 146 байгууллагын цахим хуудсыг хамруулсан.

Тодруулбал судалгаанд:

- Монгол улсын яам -15;
- Монгол улсын хэрэгжүүлэгч агентлаг - 19
- Монгол улсын тохируулагч агентлаг - 10;
- Нийслэлийн захиргаа - 10
- Улсын Их Хурал болон түүний харъяа байгууллага -9
- Төрийн өмчит аж ахуй нэгж байгууллага -83 хамрагдсан.

Төрийн захиргааны байгууллагуудын цахим хуудсанд үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал гэсэн 4-н шалгуур үзүүлэлтийг гол болгосон бол,

Төрийн өмчит байгууллагуудад төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал гэсэн 2 үзүүлэлтийг шалгуур болгосныг анхаарч үзэх хэрэгтэй

1.3 МОНИТОРИНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Уг мониторингийн арга зүйд ашиглагдсан үндсэн үзүүлэлтүүд нь тухайн төрийн байгууллага хэр ил тод байгааг хэмжихэд чиглэгдсэн.

Үзүүлэлтүүдийг боловсруулахдаа ХЭМЖИГДЭХҮЙЦ, ХЭРЭГЖИХҮЙЦ, БОДИТОЙ байх зарчмыг баримталсан. Мэдээллийн агуулгын шинжилгээг хийх нийтлэг шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллага ил тод байдлын тодорхойлолтод ашигласан үндсэн гурван үзүүлэлт, НҮБ-ын Ази Номхон Далайн Эдийн Засаг Нийгмийн Комиссын ашигласан нэг үзүүлэлтийг хослуулснаас гадна ил тод байдлыг гэхээсээ илүүтэй цахим хуудсуудын чанарыг үнэлэхэд өргөн

ашигладаг стандарт үзүүлэлтийг нэмж нийт таван үзүүлэлт бүхий дизайн боловсруулсан.

Үзүүлэлт 1. Мэдээллийн холбогдолтой байдал (Relevance): Төрөөс иргэдэд үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийг хүртэх боломжтой байдал.

Үзүүлэлт 2. Мэдээллийн найдвартай байдал (Reliability): Тухайн цахим хуудас дахь мэдээлэл хэрэглэгчдэд итгэл төрүүлэхүйц байгаа эсэхийг илэрхийлнэ.

Үзүүлэлт 3. Мэдээллийн цаг үеийн байдал (Timeliness): Цахим хуудаст цаг үеийн, ач холбогдлоо алдаагүй мэдээлэл тавьсан эсэхийг хэмжинэ (Harris, 2010).

Үзүүлэлт 4. Цахим хуудсуудын хүртээмжтэй байдал (Accessibility): Цахим хуудас нь хэрэглэгчид төрийн байгууллагад шууд хандан зөвлөгөө, мэдээлэл авах боломж олгосон, хоёр талын харилцааг хангахуйц байгаа эсэхийг хэмжинэ.

Үзүүлэлт 5. Хэрэглэхэд хялбар байдал (Usability): Хэрэглэгчид тухайн цахим хуудсыг хэрэглэхэд хялбар байгаа эсэх. Үүнд цахим хуудсуудын туслах хэрэгслүүд, үзэмж үзүүлэлт болдог.


Дээрх үндсэн таван үзүүлэлтийн тусламжтайгаар төрийн байгууллага цахим хуудсаараа дамжуулан МИТБМАЭТХ, ШДТХ-д заасан үндсэн дөрвөн хүрээний мэдээллийн ил тод байдлыг хэрхэн хангаж байгааг хэмжих юм.

Аль нэг төрийн байгууллагын цахим хуудаст хүний нөөцийн талаарх мэдээлэл шууд тавигдаагүй боловч энэ талаарх мэдээллийг авч болох холбоос (Төрийн албаны зөвлөлийн холбоос гэх мэт), мөн төсөв, санхүүгийн талаарх мэдээлэл тавигдаагүй байсан ч энэ талаарх мэдээллийг авч болох шилэн дансны нэгдэн сайттай холбогдох тусгай цэс, холбогдох албан тушаалтны хаяг зэрэг багтсан байвал дээрх хүрээний мэдээлэл агуулагдсан хэмээн үнэлэх боломжтой.

Мониторингийн арга зүйд ашиглагдсан үзүүлэлтүүдийн аль нь ил тод байдлыг илтгэхэд илүү ач холбогдолтой үзүүлэлт вэ

гэдгийг ялгаатай байдлаар тогтоосон. Эдгээр үзүүлэлтийн нийт үнэлгээний системд эзлэх ач холбогдлыг Дүрс 1-д харуулав.

Дүрс 1. Шалгуур үзүүлэлт тус бүрийн үнэлгээний системд эзлэх хувь



Мэдээллийн холбогдолтой байдал мэдээллийн ил тод байдлыг илтгэх үзүүлэлтүүдээс хамгийн өндөр буюу 30%-ийг эзэлж байгаа.

Харин тухайн мэдээлэл нь чанарын хувьд ямар мэдээлэл байна вэ гэдэгтэй холбоотой хоёр үзүүлэлт байгаа бөгөөд нийт үнэлгээний системд тус бүр 20 хувь, нийлээд 40 хувь эзэлнэ.

Эцэст нь мэдээлэл хэрхэн хүрч байна вэ гэдэгт цахим хуудасны хүртээмжтэй байдал, хэрэглэхэд хялбар байдал багтсан бөгөөд эдгээр нь илүү хэлбэрийн шинжтэй үзүүлэлт тул нийт үнэлгээний системд тус бүр 15 хувь (мэдээллийн хүртээмжтэй байдал ба хэрэглэхэд хялбар байдал), нийт 30 хувийг эзэлж байна.

Мөн үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг үнэлэхдээ өмнөх мониторингийн арга зүйд ашигласан “шалгуурыг хангасан”, “шалгуурыг хангаагүй” гэсэн үнэлгээг нарийвчилсан.

Хүснэгт 1. Тухайн үзүүлэлтийг хангаж буй түвшин

Хувь	Ил тод байдал
81-100	Бүрэн ил тод
61-80	Ил тод
41-60	Зарим талаар ил тод
0-40	Хаалттай


Дээрх таван үзүүлэлт тус бүрийн үнэлгээний түвшний дэлгэрэнгүй тайлбарыг Хавсралт 2 хэсгээс харна уу.

БҮЛЭГ 2. ГОЛ ҮР ДҮН

2.1 Нэгдсэн үр дүн

Энэ бүлэгт судалгаанд хамрагдсан нийт төрийн байгууллагуудын цахим хуудсуудын дундаж үзүүлэлтийг харьцуулж харуулах болно.

Дүрс 2. Шалгуур үзүүлэлт тус бүрийн үнэлгээний системд эзлэх хувь




Дээрх дүрсээс харахад, судалгаанд хамрагдсан байгууллагуудын цахим хуудасны ил тод байдал өмнөх жилийн үр дүнгээс бүгд өсөлттэй байгааг харж болохоор байна. 2014 онд 36,9 хувьтай байсан бол 2015 онд 52,2 хувь болж 15 орчим хувиар өссөн байна. Ингэснээр төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал нь “хаалттай” гэсэн ангилалаас “зарим талаар ил тод” гэсэн ангилалд шилжиж буй хэрэг юм. Дээрх төрийн байгууллагуудаас хамгийн өндөр үзүүлэлтийг яамдын цахим хуудас авсан ба өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад 22 орчим хувиар үзүүлэлтүүд нь сайжирчээ.

1.1.1 Мэдээллийн хамааралтай байдал

Энэ хэсэгт ЗГ-ын 143 дугаар тогтоолд цахим хуудаст тавигдсан байхаар заасан дөрвөн хүрээний дагуу 40 төрлийн мэдээллийг хэрэглэгчдэд өгч байгаа эсэхийг хэмжинэ.

Дүрс 3. Төрийн байгууллагын мэдээллийн хамааралтай байдал




Төрийн байгууллагууд өөрийн үйл ажиллагаатай хамааралтай мэдээллийг цахим хуудсандаа нийтэлдэг байдал 2014 онд 40,8 хувьтай байсан бол 2015 онд 56,4 хувьтай болон өсчээ. Дээрх дүрсээс нийслэл, дүүргүүд болон яамдууд үйл ажиллагаатай хамааралтай мэдээллээ цахим хуудсаараа ил тод нийтэлдэг гэж дүгнэгдсэн байгааг харж болохоор байна. Эсрэгээр Агентлагуудын цахим хуудас мэдээллийн хамааралтай байдлын шалгуур үзүүлэлтээр хамгийн бага хувьтай байна.

1.1.2 Мэдээллийн найдвартай байдал

Мэдээллийн найдвартай байдал гэдэгт тухайн цахим хуудас дахь мэдээлэл хэрэглэгчдэд итгэл төрүүлэхүйц байгаа эсэхийг хэмжинэ. Ийнхүү хэмжихдээ байгууллагуудын цахим хуудаст тавьсан мэдээллийн эх сурвалж, нийтэлсэн хүний овог нэр байгаа эсэх зэрэг үзүүлэлтийг авч үзсэн юм.

Дүрс 4. Төрийн байгууллагын мэдээллийн найдвартай байдал




Мэдээллийн найдвартай байдлын үзүүлэлтүүд 2014 онд 13,9 хувьтай маш хангалтгүй үр дүнтэй байсан бол 2015 оны судалгаагаар 47,1 хувь болон эрс өсчээ. Өмнөх оны судалгааны үр дүнгээр бусдаасаа өндөр үнэлгээтэй байсан тохируулагч болон Агентлагуудын цахим хуудасны найдвартай байдлын хувь энэ оны судалгааны үр дүнгээр хамгийн бага хувьтай өсөлт үзүүлсэн байна. Харин нийслэл, дүүргүүд болон яамдуудын цахим хуудасны найдвартай байдлын үзүүлэлт 50 орчим хувиар огцом нэмэгдсэн байна.

1.1.3 Мэдээллийн цаг үеийн байдал

Мэдээллийн цаг үеийн байдал гэдэгт төрийн байгууллагууд цахим хуудаст цаг үеийн, ач холбогдлоо алдаагүй мэдээлэл тавьсан эсэхийг ойлгоно (Harris, 2010). Өөрөөр хэлбэл, төрөөс иргэдэд хүргэж буй мэдээлэл цаг үеэ олсон, тогтмол давтамжтай шинэчлэгддэг бөгөөд уг мэдээллийг хэрэглэгчид хүлээн ав, ашиглах боломжтой байдлыг бүрдүүлж байгаа эсэхийг энэ үзүүлэлтээр хянах юм.

Дүрс 5. Төрийн байгууллагын мэдээллийн цаг үеийн байдал




Мэдээллийн цаг үеийн байдлын үзүүлэлт бүхий л төрийн байгууллагуудын хувьд өсөлттэй үр дүнг харуулж байна. Дээрх төрийн байгууллагуудаас аймаг, нийслэлийн болон парламентийн байгууллагуудын хувь 40 хувиас дээш буюу “зарим талаар ил тод” гэсэн ангилалд орж байгаа бол бусад

байгууллагуудын үзүүлэлт хэдийгээр өсөлттэй байгаа ч “хаалттай” гэсэн ангиллаас гараагүй хэвээр байна.

1.1.4 Мэдээллийн хүртээмжтэй байдал

Энэ үзүүлэлтээр цахим хуудас хэрэглэгчид төрийн байгууллагад шууд хандан зөвлөгөө, мэдээлэл авах боломж олгосон, хоёр талын харилцааг хангахуйц байгаа эсэхийг хэмжинэ (Drew & Nyerges, 2004, p. 57). Ингэхдээ өмнөх гурван үзүүлэлтээс ялгаатай нь мэдээллийн агуулгад бус, цахим хуудаст өөрт нь холбогдох хэмжүүрүүдийн дагуу шинжилгээ хийдэг.

Дүрс 6. Төрийн байгууллагын мэдээллийн хүртээмжтэй байдал




Мэдээллийн хүртээмжтэй байдлын хувь 43,5 хувь болсон нь өмнөх оны үр дүнтэй харьцуулж үзэхэд бага зэргийн өсөлттэй байдлыг харуулж байна. Дээрх дүрсээс харахад ихэнхи төрийн байгууллагуудын цахим хуудасны хүртээмжтэй байдлын үзүүлэлтэд эерэг өөрчлөлт гарчээ. Харин засгийн газрын Агентлагуудын үзүүлэлт 2014 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад 1 орчим хувиар буурсан сөрөг үзүүлэлттэй байна. Өмнөх жилийн судалгааны үр дүнгээр 33,8 хувьтай буюу тааруу дүгнэгдэж байсан яамдын цахим хуудасны хүртээмжтэй байдлын үзүүлэлт энэ оны судалгаагаар хамгийн өндөр ахиц гаргаж 53,3 хувь болсон нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

1.1.5 Цахим хуудсыг хэрэглэхэд хялбар байдал

Хэрэглэгчид тухайн цахим хуудсыг хэрэглэхэд хялбар байгаа эсэхийг мөн хэмжсэн. Үүнд цахим хуудасны туслах хэрэгслүүд, үзэмж, төрх, дизайн зэрэг багтана.

Дүрс 7. Төрийн байгууллагын цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдал



(Weakley, 2004). Аливаа цахим хуудас нь иргэдийн интернэтхэрэглэх чадварт нийцсэн, энгийн, ойлгомжтой байх нь хэрэглэхэд хялбар байдлыг илтгэх чухал үзүүлэлт болдог.

Цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдлын үзүүлэлт бусад үзүүлэлттэй харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлттэй гардаг. Энэ жилийн хувьд ч мөн адил 75,7 хувьтай байгаа нь эерэг үр дүн болж байна. Дээрх дүрсээс харахад аймгуудын цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдал өмнөх оны үр дүнгээс бууралттай байгааг эс тооцвол бусад төрийн байгууллагуудын үзүүлэлтүүд тодорхой хувиар өсөлттэй байна. Гэвч засгийн газрын хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлагуудын үзүүлэлт хэдийгээр өссөн үр дүнг харуулж буй боловч бусад төрийн байгууллагуудаас харьцангуй бага хувьтай буюу “ил тод байдал”-ын ангилалд багтахуйц үр дүнг үзүүлж чадахгүй байна.

2.2 ЯАМДЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ҮЗҮҮЛЭЛТ

Энэ бүлэгт одоо үйл ажиллагаа явуулж буй нийт 15 яамны албан ёсны цахим хуудаст хийсэн мониторингийн нэгдсэн үр дүнг харуулна.

Яамдын цахим хуудсыг таван үзүүлэлт тус бүрээр болон нийлбэр оноогоор өмнөх жилийн судалгааны үр дүнтэй харьцуулан харуулав.

Хүснэгт 2. Яамдын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт (хувь)

№	Яам	Нийлбэр оноо	
		2014	2015
1	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам	32,1	45,3
2	Батлан хамгаалахын яам	33,1	46,2
3	Барилга, хот байгуулалтын яам	38,5	59,7
4	Боловсрол, соёл шинжлэх ухааны яам	43,3	65,9
5	Гадаад хэргийн яам	27,8	56
6	Хууль зүйн яам	25,8	53,9
7	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	35,9	59,5
8	Сангийн яам	39,2	74
9	Хүнс, хөдөө аж ахуйн яам	37,1	64,9
10	Эрүүл мэнд, спортын яам	24,4	63,3
11	Эрчим хүчний яам	45,5	67,4
12	Зам тээврийн яам	46,1	67,4
13	Хөдөлмөрийн яам	48,2	53,8
14	Уул уурхайн яам	40,7	45,2
15	Аж үйлдвэрийн яам	-	55,2
Яамдын дундаж		36,7	58,5
Ерөнхий дундаж		36,9	52,2

2015 оны яамдын дундаж үзүүлэлт нийт төрийн байгууллагуудын дундаж үзүүлэлтээс 6 хувиар өндөр гарсан байна. Мөн 2014 оны дундаж үзүүлэлттэй харьцуулж үзэхэд 20 гаруй хувиар дээшилсэн эерэг үзүүлэлттэй байна.


Нийт яамдын үзүүлэлтүүд өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 13-40 хувиар нэмэгдсэн нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Нийт төрийн байгууллагуудын үзүүлэлтүүдийг хооронд нь эрэмбэлж үзэхэд, Сангийн яам 74 оноо (ил

тод байгууллага) авсан үзүүлэлтээр 1-рт эрэмбэлэгдэж байна.

Судалгааны үр дүнгээр яамдуудаас хамгийн өндөр үзүүлэлттэй нь 74 хувьтай байгаа бол 2014 оны судалгаагаар яамдын хамгийн өндөр үзүүлэлт нь 48,2 хувьтай Хөдөлмөрийн яам байсан байна. Хэдийгээр зарим яамдуудын ранк өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад буурсан боловч хувийн авч буй оноо нь бүгд дээшилсэн байна. Энэ нь 2015 онд нийт төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал жигд сайжирсан байгааг илтгэж байна.

Яамдуудын цахим хуудасны мониторингийн үр дүнг таван үзүүлэлт тус бүрээр, хоёр оноор харьцуулсан үр дүнг дараах графикт харууллаа.

Дүрс 8. Яамдын цахим хуудасны ил тод байдал (хувь)



Дээрх хүснэгтээс харахад 2015 оны судалгааны үр дүнгүүд өнгөрсөн оныхоос бүгд ахисан үзүүлэлттэй байна.


Эдгээрээс “мэдээллийн хамааралтай байдал”, “мэдээллийн найдвартай байдал” гэсэн үзүүлэлт 6-10 оноогоор дээшилсэн бол бусад 3 үзүүлэлт нь 1,5-3 оноогоор өссөн байдалтай харагдаж байна.

2.2.1 Үйл ажиллагааны ил тод байдал

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг авч үзэхдээ 1. Байгууллагын ерөнхий мэдээлэл, 2. Байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл гэсэн хоёр хэсэгт ангилан авч үзсэн.

Яамдын цахим хуудсанд хийсэн мониторингийн үр дүнгээс харахад нийт судалгаанд хамрагдсан яамдын үзүүлэлтүүд өмнөх судалгааны үр дүнгээс өссөн байдалтай байна.

Дүрс 9. Яамдын ерөнхий мэдээлэл (хувь)




Дээрх дүрсээс харахад яамдууд “эрхэм зорилго”, “үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилт”-ыг цахим хуудсанаа байршуулдаг байдал нь нэмэгдэж “бүрэн ил тод” гэсэн үнэлгээнд орохуйц болсон байна. Харин “үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл”-ийг цахим хуудсандаа байршуулдаг байдал өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад 30 орчим хувиар нэмэгдсэн боловч бусад шалгуур үзүүлэлтээс доогуур хувьтай дүгнэгдсэн байна.

Яамдын үйл ажиллагааны ил тод байдал 2014 онд 53,3 хувьтай байсан бол 2015 онд 67,1 хувь болж өссөн үзүүлэлттэй байна.

2.2.2 Хүний нөөцийн ил тод байдал

Яамдын цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт 60,2 байгаа нь “бүрэн ил тод байдал”-н шалгуурт харахан хүрэхгүй байгаа ч өмнөх жилийн судалгааны үр дүнгээс өсөлттэй үр дүнг харуулж байна.

Дүрс 10. Яамдын хүний нөөцийн ил тод байдал (хувь)




Өмнөх оны судалгаагаар “хүний нөөцтэй холбоотой мэдээлэл” маш бага хувьтай цахим хуудсанд тавигдаж байсан ба тэдгээр мэдээллийн эх сурвалж нь огт тодорхойгүй байсан бол энэхүү судалгааны үр дүнгээр үзүүлэлт тус бүр нэлээд хувиар өссөныг “эх сурвалж тодорхой байх” гэсэн шалгуур үзүүлэлтийн үр дүнгээс харж болохоор байна.

2015 оны судалгааны үр дүнгээр бүхий л үзүүлэлт өсөлттэй байгааг харж болохоор байна.

2.2.3 Төсөв санхүүгийн ил тод байдал

Яамдын цахим хуудасны төсөв санхүүгийн ил тод байдлыг авч үзэхэд өмнөх судалгааны үр дүнгээс сайжирчээ. Төсөв санхүүгийн ил тод байдлын дундаж үзүүлэлтийг дараах дүрсээс дэлгэрэнгүй харна уу.

Дүрс 11. Яамдын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)



Дээрх дүрсээс харахад төсөв санхүүгийн ил тод байдал өмнөх судалгааны үр дүнгээс дунджаар хоёр дахин буюу 28,8 хувь байснаас 56,6 хувь болж өссөн байна. Шалгуур үзүүлэлт тус бүрээр авч үзвэл өмнөх оны судалгааны үр дүнгээр 0,7 хувьтай байсан “төсөв санхүүгийн мэдээллийн эх сурвалж тодорхой байдал” 17,8 хувь болж дээшилсэн нь хамгийн өсөлттэй үр дүнг харуулж байна.

Төсвийн ил тод байдлыг үнэлсэн дараах 11 үзүүлэлтээс “шилэн дансны тусгай цэс” нь бүх яамдын цахим хуудсанд байснаараа 100 эерэг үр дүнг харуулж байна. Мөн өмнөх оны судалгааны үр дүнтэй харьцуулан харвал ихэнхи нь нэлээд хувиар өсөлттэй байгааг дараах дүрсээс харж болохоор байна.


Харин төсөвт оруулсан нэмэлт өөрчлөлт, төсвийн төсөл зэрэг мэдээллийг яамдууд өмнөх онуудтай ижил маш хангалтгүй түвшинд мэдээллэсэн хэвээр байна.

Хэдийгээр яамдын төсөв санхүүгийн ил тод байдлын оноо тодорхой хэмжээгээр дээшилсэн хэдий ч хаалттай гэсэн ангиллаас гарах хэмжээнд хүрэхгүй байна.

2.2.4 Худалдан авах ажиллагааны ил тод байдал

Яамдын хувьд ХАА-ны тухай мэдээлэл буюу тендертэй холбоотой баримт бичгийг цахим хуудастаа цаг тухай бүрт нь байршуулах ёстой юм.

Дүрс 12. Яамдын ХАА-ны ил тод байдал (хувь)



Дээрх дүрсээс харахад 2014 оны хувьд яамдын ХАА-ны ил тод байдал 18,8 хувьтай байсан нь энэхүү судалгааны дүнгээр 43,6 хувь болж нэлээд хэмжээгээр өссөн байна.

Мөн дээрх дүрсээс харахад өмнөх жилийн судалгааны үр дүнгээс төдийлэн дээшлээгүй ч гэсэн ХАА-нд хийсэн аудитын дүгнэлт, тайланг цахим хуудастаа байршуулах байдал нь нэмэгджээ. Харин эсрэгээрээ худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлангаа тавих байдал нь буурсан байна.

2.3 ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГУУДЫН ЦАХИМ ХУУДСЫН ҮЗҮҮЛЭЛТ

Энэ хэсэгт одоо үйл ажиллагаа явуулж буй нийт 29 засгийн газрын агентлагуудын албан ёсны цахим хуудаст хийсэн мониторингийн нэгдсэн үр дүнг харуулна.

Агентлагуудын цахим хуудсыг 5 үзүүлэлт тус бүрээр болон нийлбэр оноогоор 2014 оны судалгааны үр дүнтэй харьцуулан харуулав.

Хүснэгт 3. Агентлагуудын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт (хувь)

№	Нэрс	Нийлбэр оноо	
		2014	2015
1	Ашигт малтмалын газар	47.2	52
2	Архивын ерөнхий газар	39	50.1
3	Газрын тосны газар	16.3	46.1
4	Гаалийн ерөнхий газар	43.4	54.9
5	Иргэний харъяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар	45.1	41.2
6	Хөрөнгө оруулалтын газар	16.8	34
7	Газрын харилцаа, барилга геодези, зураг зүйн газар	17.4	40.3
8	Иргэний нисэхийн ерөнхий газар	32.8	31.7
9	Мал эмнэлэг үржлийн газар	30.4	48.8
10	Нийгмийн даатгалын ерөнхий газар	30.9	45.3
11	Оюуны өмчийн газар	20.4	34.5
12	Татварын ерөнхий газар	58.6	47
13	Худалдан авах ажиллагааны газар	43.7	52.7
14	Улсын бүртгэлийн ерөнхий газар	49.4	56.6
15	Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар	37.3	43.4
16	Хүүхдийн төлөө үндэсний газар	30	48.2
17	Цаг уур орчны шинжилгээний газар	47.9	18.2
18	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	48.4	52.3
19	Тахарын ерөнхий газар		48.8
20	Зэвсэгт хүчний жанжин штаб	14.6	29.5
21	Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар	23.1	48.1
22	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	53.7	50.6
23	Онцгой байдлын ерөнхий газар	29.4	47.8
24	Хил хамгаалах ерөнхий газар	34.6	47.1
25	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар	37.6	47.1
26	Стандартчилал хэмжил зүйн газар	33.5	39.9
27	Тагнуулын ерөнхий газар	26.3	35.7


28	Төрийн өмчийн хороо	52.7	56.4
29	Цагдаагийн ерөнхий газар	41.3	67.1
Агентлагуудийн дундаж		35.3	45.7
Ерөнхий дундаж		36.9	52.2

Агентлагуудын дундаж үзүүлэлт энэ онд нийт төрийн байгууллагуудын дундаж үзүүлэлтээс 6,5 пунктаар бага түвшинд байна. Харин 2014 оны судалгааны дундаж үзүүлэлтээс 10,4 пунктаар өссөн үзүүлэлттэй байна.

Бүх хэрэгжүүлэгч агентлагууд зарим талаар ил тод гэсэн ангилалд багтаж байна.

Вэб мониторингийн үр дүнг таван үзүүлэлтийн дагуу хоёр оноор харьцуулан гаргаж өөрчлөлтийг дараах дүрсэд харууллаа.

Дүрс 13. Агентлагуудын цахим хуудасны ил тод байдал (хувь)



2015 онд 5 үзүүлэлтийн 1 нь болох мэдээллийн хүртээмжтэй байдал доошилсон бол бусад үзүүлэлтүүд дунджаар 2.05 пунктаар өссөн үр дүн харагдаж байна.

хэрэглэхэд боломжтой гэсэн ангилалд шилжсэн эерэг үзүүлэлт гарсан байна.


2.3.1 Үйл ажиллагааны ил тод байдал

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг авч үзэхдээ 1. Байгууллагын

ерөнхий мэдээлэл. 2. Байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл гэсэн хоёр хэсэгт ангилан авч үзсэн.

Агентлагуудын цахим хуудсанд хийсэн мониторингийн үр дүнгээс харахад нийт судалгаанд хамрагдсан агентлагуудын танилцуулга болох ерөнхий мэлээллээ цахим хуудастаа тавих байдал төдийлэн дээшлээгүй байна.

Дүрс 14. Агентлагуудын ерөнхий мэдээлэл (хувь)



Дээрх үр дүнгээс харахад байгууллагууд тэргүүлэх чиглэлээ цахим хуудас дээрээ байршуулах байдал нь өмнөх судалгааны үр дүнгээс багагүй хувиар өсч 42.1 хувь. үйл ажиллагааны стратеги зорилго зорилтоо тавих байдал 6.7 хувиар өссөн байгаа бол эрхэм зорилгоо тавих байдал 28.4 хувиар өссөн үзүүлэлт гарсан байна.


Олон нийттэй харилцах мэргэжилтний овог нэр гэсэн үзүүлэлт 31 хувиар буюу хамгийн их хувиар өссөн байна. Тухайн цахим хуудаснаас шууд агентлагийн мэргэжилтэнтэй холбогдох боломж хамгийн бага хувиар өссөн үзүүлэлт байсан хэдий ч 2014 онд огт байхгүй байсан бол энэ онд 5.3 болж нөгөө талаараа эерэг үр дүн гарсан байна.

Ерөнхийд нь дүгнэхэд агентлагуудын үйл ажиллагааны ил тод байдал 2014 онд 51.1 хувьтай байсан бол 2015 онд 53 хувь болж 1.9 пунктаар өссөн үзүүлэлттэй байна.

2.3.2 Хүний нөөцийн ил тод байдал

Агентлагуудын цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдал өмнөх судалгааны үр дүнгээс өссөн үзүүлэлттэй байна. 2014 оны байдлаар агентлагуудын хүний нөөцийн ил тод байдал 24.6 хувьтай байсан бол 2015 онд 38.0 хувьтай болж 13.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Дүрс 15. Агентлагуудын хүний нөөцийн ил тод байдал (хувь)



2014 онд нийт агентлагууд сул орон тооны талаарх мэдээллээ дөнгөж 11.9 хувьтай ил тод байршуулж байсан бол энэ онд 47.4 хувьтай байршуулж 35.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2.3.3 Төсөв санхүүгийн ил тод байдал

Агентлагуудын цахим хуудасны төсөв санхүүгийн ил тод байдал нь өмнөх онтой харьцуулахад 16.8 пунктаар өссөн үзүүлэлттэй байна. Төсөв санхүүгийн ил тод байдлын дундаж үзүүлэлтийг дараах дүрсээс дэлгэрэнгүй харна уу.

Дүрс 16. Агентлагуудын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)




Төсөв санхүүгийн мэдээллийн эх сурвалжийн тодорхой байдал болон цаг үеийн тодорхой байдал нь ижил 5.1 хувиар, харин төсөв санхүүгийн талаарх мэдээлэл оруулсан байдал нь 6.7 хувиар өссөн байна.

2.3.4 Худалдан авах ажиллагааны ил тод байдал

Агентлагуудын хувьд ХАА-ны тухай мэдээллээ цахим хуудастаа ил тод байршуулах байдал мөн өмнөх судалгааны үр дүнгээс ялимгүй нэмэгдсэн байдалтай байна. 2014 онд 25.9 байсан бол энэ жил 26.3 хувь болж 0.4 пунктаар өссөн үзүүлэлттэй байна.

Дүрс 17. Агентлагын ХАА-ны ил тод байдал (хувь)



Нарийвчилсан үзүүлэлтүүдээс харвал ХАА-ны талаарх мэдээлэл тавигдсан байдал. мэдээллийн эх сурвалжийн найдвартай байдлын үзүүлэлтүүд бараг өөрчлөгдөөгүй бол ХАА-ны талаарх мэдээллийн цаг үеийн байдлын үзүүлэлт 2 орчим хувиар өссөн байна.

Агентлагууд өөрсдийн цахим хуудастаа *тендерийн урилга. зарыг* байршуулсан байдал 2014 оны байдлаар 72.2 хувьтай байсан бол энэ жил 57.9 хувь. тендер шалгаруулалтын талаарх мэдээллийг байршуулсан байдал 33.3 хувьтай байсан бол энэ жил 15.8 хувь болж дунджаар 16 пунктаар буурчээ. *Худалдан авсан бараа. ажил үйлчилгээний тайлан /5 сая.төг-с дээш/* 2014 онд 5.6 хувьтай байсан бол энэ жил 47.4 хувь болж хамгийн их өсөөлтэй үзүүлэлтээр нэрлэгдсэн. Мөн *ХАА-нд хийсэн аудитын тайлан дүгнэлтийг* байршуулсан байдал 2014 онд 0 хувьтай байсан бол 2015 онд 10.5 хувь болж өссөн эерэг үр дүнг харж болохоор байна. Энэ жил арга зүйд нэмэгдсэн үзүүлэлтүүд дунджаар 32.8 хувьтай үнэлэгджээ. *Ялангуяа Цалингийн зардлаас бусад 5 сая.төг-с дээш үнийн дүн бүхий орлого. зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр. гүйлгээний агуулга* гэсэн үзүүлэлт 78.9 хувь гэж үнэлэгдсэн байна.

2.4 УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРГАА, ДҮҮРГҮҮДИЙН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ

Энэ хэсэгт НДТГ-ын цахим хуудас. УБ хотын захирагчийн ажлын албаны цахим хуудас болон 9 дүүргийн ЗДТГ-ын цахим хуудсыг хамруулсан болно.

Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудсыг 5 үзүүлэлт тус бүрээр болон нийлбэр оноогоор 2014 оны судалгааны үр дүнтэй харьцуулан харуулав.

Зураг 1. Дүүргүүдийн ил тод байдлын үзүүлэлт1



УБ хотын захирагчийн ажлын албаны цахим хуудас ил тод. бусад 8 цахим хуудас нь зарим талаар ил тод. 1 дүүргийн цахим хуудас хаалттай гэсэн ангилалд хамаарч байна.

Үүнээс дүгнэхэд ил тод цахим хуудасны тоо 2-оор нэмэгдэж. харин 1 цахим хуудас үзүүлэлттээ өсгөж хаалттай ангиллаас зарим талаар ил тод ангилалд шилжиж . 1 дүүрэг хаалттай цахим хуудастай хэвээр байна.

Хүснэгт 4. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудасны ил тод байдал (хувь)


№	Дүүргүүдийн нэрс	Нийлбэр оноо	
		2014	2015
1	НЗДТГ	40.9	57.3
2	УБ хотын захирагчийн ажлын алба	22.6	62.7
3	БГД-ийн ЗДТГ	43.4	67
4	БХД-ийн ЗДТГ	22.1	39.5
5	БЗД-ийн ЗДТГ	30.5	55.2
6	БНД-ийн ЗДТГ	25.4	59.4

¹0-40 оноо улаан өнгөөр, 41-60 оноог шар өнгөөр, 61-80 оноог ногоон өнгөөр тэмдэглэсэн.

7	ЧД-ийн ЗДТГ	39.6	54.6
8	СБД-ийн ЗДТГ	34	49.5
9	СХД-ийн ЗДТГ	39.2	48.7
10	ХУД-ийн ЗДТГ	20.1	65.8
11	НД-ийн ЗДТГ	31.1	54.9
Нийслэлийн дундаж		31.7	55.9
Ерөнхий дундаж		36.9	52.2

Нийслэлийн захиргаа дүүргүүдийн цахим хуудасны дундаж үзүүлэлт энэ онд нийт төрийн байгууллагуудын дундаж үзүүлэлтээс 3.3 пунктаар өндөр түвшинд байна. Бүх цахим хуудасны ил тод байдлын хувь өссөн бөгөөд дундаж үзүүлэлтийг харьцуулж үзэхэд өмнө оноос 24.2 пунктаар өссөн үзүүлэлттэй байна. 2014 онд эхний 20 байранд багтсан цахим хуудас энэ бүлэгт байгаагүй бол энэ онд 3 цахим хуудас эхний 20 байранд багтсан үр дүн гарсан байна. Тухайлбал: БГД-ийн цахим хуудас 2014 онд 43.4 хувь 21-р байраас 2015 онд 67 хувиар 2-р байрт. ХУД-ийн цахим хуудас 2014 онд 20.1 хувь 42-р байрт байсан бол 2015 онд 65.8 хувиар 9-р байр луу урагшилсан байна.

Дүрс 18. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудасны ил тод байдал (хувь)




Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудасны ил тод байдал өмнөх онтой харьцуулахад 15 пунктаар нэмэгдсэн байна. Энэ бүлэгт хамаарах цахим хуудсуудын үзүүлэлт өмнөх онтой харьцуулахад *мэдээллийн хамааралтай байдал* 11.8 хувиар, *мэдээллийн найдвартай байдал* 5.5 хувиар, *мэдээллийн хүртээмжтэй байдал*

4.2 хувиар өссөн бол хэрэглэхэд хялбар байдлын үзүүлэлт 3.1 хувиар. мэдээллийн цаг үеийн байдал 3.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үндсэн 5 үзүүлэлтийн зарим нь өссөн, зарим нь буурсан харагдаж байгаа ч 2014 онд дундаж үзүүлэлт 8.2 хувь байсан бол 2015 дундаж үзүүлэлт 11.1 хувь болж өмнөх оноос 2.9 пунктаар өссөн байна.

2.4.1 Үйл ажиллагааны ил тод байдал

Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудсанд хийсэн мониторингийн үр дүнгээс харахад энэ бүлэгт хамрагдсан нийт цахим хуудсуудын танилцуулга болох ерөнхий мэлээллээ цахим хуудаастаа тавих байдал 18.2-54.5 хувиар буюу маш өндөр өсөлттэй үр дүн гарсан байна.

Дүрс 19. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн ерөнхий үзүүлэлт (хувь)



Бусад төрийн байгууллагуудын цахим хуудастай харьцуулахад тэргүүлэх чиглэлийн мэдээллийг байршуулсан байдал хамгийн өндөр хувиар буюу 54.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Эрхэм зорилго болон үйл ажиллагааны стратеги зорилго, зорилтын мэдээллээ 90.9 хувьтай байршуулсан байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 18.2


Байгууллагын олон нийттэй харилцах мэдээллийн үзүүлэлтүүд бүгд өссөн дүнтэй тэр дундаа байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам зааврыг байршуулсан байдал

81.8 хувиар өссөн байна. Нэг сонирхолтой үр дүн гарсан нь байгууллагын олон нийттэй харилцахтай холбоотой үзүүлэлтүүдээс 3 үзүүлэлт өмнөх оны байдлаасаа огт өөрчлөлтгүй гарсан байв. Нийт үзүүлэлтүүдийн өсөлтийн хувийг 2014 онтой харьцуулахад дунджаар 27.1 пунктаар өссөн.

2.4.2 Хүний нөөцийн ил тод байдал

Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдал өмнөх судалгааны үр дүнгээс өссөн үзүүлэлттэй байна. 2014 оны байдлаар эдгээр цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдал 24.7 хувьтай байсан бол 2015 онд 48.8 хувьтай болж 24.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Дүрс 20. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн хүний нөөцийн ил тод байдал (хувь)



Хүний нөөцийн талаарх мэдээлэл байршуулсан байдал 20.2 хувиар нэмэгдсэн ч цаг хугацааны хувьд тохирсон, тодорхой байдал нь 1.3 хувиар буурсан байна. Харин эх сурвалжийн тодорхой байдал яг нэг дахин нэмэгдсэн үр дүн гарсан байна.


2014 онд нийслэлийн захиргаа, дүүргүүд сул орон тооны талаарх мэдээллээ дөнгөж 11.7 хувьтай ил тод байршуулж байсан бол энэ онд 54.5 хувь болж 42.8 хувиар өссөн эерэг үр дүн гарсан байна. Энэ жил шинээр нэмсэн Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам, хүний

нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл зэрэг нь ижил 81.8 хувьтай үнэлэгдсэн байна.

2.4.3 Төсөв санхүүгийн ил тод байдал

Энэ онд нийслэлийн захиргаа, дүүргүүдийн төсөв санхүүгийн ил тод байдлын хувь өмнөх оноос 40.3 пунктаар өссөн байна. Ингэж өндөр хувиар өссөн нь энэ жил тухайн байгууллагын вебсайт шилэн дансны тусгай цэстэй байвал тухайн цэсээр дамжин орж төсөв, санхүүгийн талаарх мэдээлэлд мониторинг хийсэнтэй холбоотой юм.

Дүрс 21. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)



Дээрх дүрсэд харагдаж байгаачлан мэдээллийн эх сурвалжийн тодорхой байдал хамгийн өндөр хувиар буюу 15.9 хувиар өссөн байна.


байршуулаагүй байсан тухайн жилийн төсөвт оруулсан нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээлэл энэ жил 18.2 хувьтай тавигдсан байна. Энэ жилийн мониторингийн судалгааны нэг онцлог нь шилэн дансны тусгай цэсээр дамжин орж төсөв санхүүгийн талаарх мэдээлэлд шинжилгээ хийх байсан. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудаснууд бүгд шилэн дансны тусгай цэстэй байсан бөгөөд холбоосууд нь бүгд ажиллагаатай байв. Аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл бусад бүлэгт хамаарах

төрийн байгууллагуудаас харьцангуй өндөр үзүүлэлт гарчээ.

2.4.4 Худалдан авах ажиллагааны ил тод байдал

Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудасны хувьд худалдан авах ажиллагааны ил тод байдал хаалттай ангиллаас зарим талаар ил тод ангилал руу шилжсэн байна.

Дүрс 22. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн ХАА-ны ил тод байдал (хувь)



Худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг цахим хуудасдаа байршуулахдаа тухайн тендерийн ерөнхий мэдээллийг тавихаас гадна хүлээн авах, нээх газар, цаг хугацаа, хүлээн авах хүний нэрийг бичиж буй байдал нэмэгдсэн нь ХАА-ны мэдээллийн эх сурвалж тодорхой байдлыг 8.2 хувиар өсгөсөн үзүүлэлт болж байна. Цаг хугацааны хувьд тохирсон, тохиромжтой байдал их биш ч гэсэн тодорхой хувиар өссөн байна.

**2.5 ПАРЛАМЕНТИЙН ХАРЬЯА
БАЙГУУЛЛАГУУДЫН ЦАХИМ
ХУУДСЫН ҮЗҮҮЛЭЛТ**

Энэхүү бүлэгт парламентын харьяа байгууллагуудын цахим хуудасны ил тод байдлын үнэлгээг харуулна.

Байгууллага бүрийг 2014 болон 2015 оны судалгааны үр дүнгээр харьцуулан, дундаж хувийг ерөнхий төрийн байгууллагуудын дундажтай харьцуулан дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 5. Парламентын харьяа байгууллагын цахим хуудасны ил тод байдлын үнэлгээ (хувь)

№	Байгууллагын нэрс	Нийлбэр оноо	
		2014	2015
1	ТАЗ	36.5	46.4
2	АТГ	32.9	58.5
3	СЗХ	35.2	48.9
4	СЕХ	46.1	73.3
5	ХЭҮК	48	45.9
6	ҮАГ	40	44.7
7	ҮСХ	45.3	47.3
8	Монгол банк	37.6	66.5
9	УИХ	32.6	52
Парламентын байгууллагын дундаж		39.3	53.7
Ерөнхий дундаж		36.9	52.2


Парламентын харьяа байгууллагуудын цахим хуудасуудын дундаж нь 53,7 хувьтай байгаа нь ерөнхий дундажаас 1,5 хувиар, өмнөх жилийн үр дүнгээс 14 орчим хувиар өссөн үзүүлэлт юм.

2014 оны судалгаанаас хойш хамгийн өндөр өсөлт үзүүлсэн цахим хуудастай байгууллагуудыг дурьдвал, Монгол банк 37,6 хувиас 66,5 хувь болж 30 орчим хувиар, АТГ, СЕХ зэрэг байгууллагууд мөн 28 орчим хувиар ахиц гаргасан байгааг сайшаалтай байна.

Судалгааны үр дүнгээр 40 хувиас доош үнэлгээтэй буюу “бүрэн хаалттай” гэсэн ангилалд хамаарах цахим хуудас байхгүй болсон ч ТАЗ, ҮАГ, ХЭҮК зэрэг газрууд цаашид ч гэсэн цахим хуудасны ил тод байдлаа нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Парламентын байгууллагуудын цахим хуудсуудын ил тод байдлыг хэмжиж буй 5-н үзүүлэлт тус бүрээр үр дүнг 2 оноор харьцуулан дор харууллаа.

Дүрс 23. Парламентын харьяа байгууллагуудын ил тод байдлын үнэлгээ(хувь)




Цахим хуудсыг хэмжиж буй 5-н шалгуур үзүүлэлт бүгд өсөлттэй үр дүнг харуулж байна. Ялангуяа мэдээллийн найдвартай байдал 2014 оны судалгааны үр дүнгээр 20 онооноос 0,2 –ыг авч байсан бол, 2015 оны судалгаагаар 7,9 болж нэлээд өсөлттэй үр дүнг үзүүлжээ. Бусад 4-н үзүүлэлтийн хувьд тус бүртээ 1-3 функтаар өссөн байгааг дээрх хүснэгтээс харж болохоор байна.

2.5.1 Үйл ажиллагааны ил тод байдал

Байгууллагын ерөнхий мэдээлэл буюу эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилго, зорилт, тэргүүлэх чиглэлээ тавьсан байдал сайн үр дүнтэй байна.

Дүрс 24. Парламентын харьяа байгууллагуудын ерөнхий мэдээллийн үнэлгээ (хувь)



Үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилтыг цахим хуудсандаа тавьсан


байдал 100 хувийн үзүүлэлттэй байгаан нь 2014 оны үр дүнгээс 80 орчим хувиар өссөн үзүүлэлт байна. Цахим хуудсандаа эрхэм зорилгоо байршуулсан байдал 88,9 хувьтай, тэргүүлэх чиглэлээ байршуулсан байдал нь 77,8 хувьтай байгаа нь 2014 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад өссөн үзүүлэлтийг илэрхийлж байна.

2014 оны судалгааны үр дүнтэй байгууллагуудын олон нийттэй харилцах мэдээллээ тавих байдлыг нь харьцуулж харвал, үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт 44,4 хувиас 22,2 хувь буурсан, бусад үзүүлэлтийн хувьд ямар нэгэн байдлаар өссөн үзүүлэлтийг харуулж байна.

2.5.2 Хүний нөөцийн ил тод байдал.

Байгууллагуудын хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлтүүдийг хүний нөөцийн мэдээлэл байгаа эсэх, тус мэдээллийн эх сурвалж байгаа эсэх, цаг хугацааны хувьд тохирсон байдал зэрэг шалгуураар дараах хүснэгтэнд харууллаа.

Дүрс 25. Парламентын харьяа байгууллагуудын хүний нөөцийн ил тод байдал(хувь)



Хүний нөөцийн ил тод байдлын үнэлгээ 24,4 хувьтай байгаа нь 2014 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад 12 хувиар өссөн үзүүлэлт байна. Мэдээллийн эх сурвалж тодорхой байдал өмнөх жилийн судалгааны үр дүнгээс ахицтай байгаа ч бусад 2 үзүүлэлтийн хувьд 1-2 функтаар буурсан байдалтай байна.


Албан хаагчийн ёс зүйн дүрэм байгууллагуудын цахим хуудсанд 88,9 хувьтай, сул орон тооны зар 55,6 хувьтай, хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам 11,1 хувьтай байгаан нь 2014 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад бүхий л үзүүлэлтийн хувьд өссөн байна.

Ялангуяа сул орон тооны зар 2014 оны судалгаагаар 9,5 хувьтай байснаа 55,6 хувь болж 50 орчим хувиар эрс нэмэгджээ.

2.5.3 Төсөв санхүүгийн ил тод байдал

Төсөв, санхүүгийн ил тод байдалд үндэслэсэн үзүүлэлтүүдийг доорх үр дүнгүүдээр илэрхийлж байна.

Дүрс 65. Парламентын харьяа байгууллагуудын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)



Парламентийн байгууллагуудын төсөв санхүүгийн талаарх мэдээллээ нийтэлж байгаа байдал 20,8 хувьтай, тус мэдээллүүдийнхээ эх сурвалжийг тодорхой нийтлэх байдал 11,1 хувьтай, цаг хугацааны тохиромжтой үед нь оруулж буй байдал 12,3 хувьтай байна. 2014 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад төсөв санхүүгийн холбогдолтой мэдээллийнхээ эх сурвалжийг оруулах байдал 0 байсан бол 11,1 болж өссөн нь бусад үзүүлэлтэй


харьцуулахад эрс өсөлтийг харуулж байна.

Ерөнхийдөө парламентын харьяа байгууллагуудын төсөв, санхүүгийн мэдээллийн ил тод байдал 44,1 хувьтай байгаа нь 2014 оны судалгааны үр дүнтэй харьцуулахд 15 орчим хувиар сайжирсан үзүүлэлтийг харуулж байна.

2.5.4 Худалдан авах ажиллагааны ил тод байдал

ХАА-ны ил тод байдлын дундаж үнэлгээг дор харууллаа.

Дүрс 26. ХАА-ны ил тод байдал (хувь)



Парламентын харьяа байгууллагуудын ХАА-ны ил тод байдлын дундаж үнэлгээ 36,9 хувьтай байгаа нь “бүрэн хаалттай” гэсэн ангилалд орохуйц үзүүлэлт юм. Гэвч 2014 оны судалгааны үр дүнтэй харьцуулан үзвэл 19,4 хувиас 17,5 хувиар өсөлттэй байгааг илтгэх үзүүлэлт болж байна.

ХАА-ны талаар мэдээлэл байгаа эсэх 16,2 хувьтай, тус мэдээллийн эх сурвалж байгаа эсэх 10,2 хувьтай, цаг хугацааны хувьд тохиромжтой байдал 10,5 хувьтай байгаа нь

бүхий л үзүүлэлтээр өмнөх жилийн үнэлгээнээс өсөлттэй үр дүнтэй байна. Ялангуяа мэдээллийн эх сурвалжийг байршуулах байдал нэлээд их хувиар өссөн байна.

Худалдан авсан бараа үйлчилгээний тайлан, тендерийн урилга, ХАА-нд хийсэн аудит болон бусад хяналт, шалгалтын үр дүнгүүд 2014 судалгаатай харьцуулагдаж болох бөгөөд бүгд 20-30 хувиар өссөн, тендер шалгаруулалтын талаарх мэдээлэл хэвэндээ байгааг харж болохоор байна.

Харин энэ жилээс шинээр үнэлэгдэж буй шалгууруудын хувьд, 5-саяас дээш мөнгөн гүйлгээний баримт, тендерт оролцохыг хүсэгчдийн шалгуур үзүүлэлт зэрэг нь бусад үзүүлэлттэй харьцуулахад өндөр хувьтай дүгнэгдсэн бол үлдсэн 3-н шалгуурын хувьд 11,1 хувьтай байгаа нь төдийлөн сайн биш үзүүлэлт юм

**2.6 ТӨРИЙН ӨМЧИТ
БАЙГУУЛЛАГУУДЫН ЦАХИМ
ХУУДАСНЫ ҮЗҮҮЛЭЛТ**


Энэхүү бүлэгт төрийн өмчит хуулийн этгээдүүдийн цахим хуудсан дахь үзүүлэлт, тэр дундаа шилэн дансны хуулийн хэрэгжилтийн ил тод байдлын үнэлгээг харуулна.

2.6.1 Мэдээллийн хүртээмжтэй байдал

Төрийн өмчит хуулийн этгээдүүдийн хувьд шилэн дансны тухай хуультай холбогдох мэдээллээ **өөрийн цахим хуудсанд, бие даасан тусгай цэс үүсгэн нийтэд мэдээлэх** ёстой байдаг.

Энэ утгаар судалгаанд хамрагдсан 83-н байгууллагад бие даасан цахим хуудас байгаа эсэхийг судалж үзэхэд дараах үзүүлэлт харагдаж байна.

Дүрс 27. ТӨХЭ-үүд бие даасан цахим хуудастай байдал (хувь)



83-н төрийн өмчит хуулийн этгээдүүдийн 50 нь буюу 60% орчим нь бие даасан цахим хуудастай байгаа бол үлдсэн байгууллагууд нь цахим хуудас байхгүй байна.

Цахим хуудасгүй байгууллагуудыг өмчийн хэлбэрээр нь авч үзвэл дараах дүр зураг ажиглагдаж байна.

Дүрс 28. Бие даасан цахим хуудасгүй байгууллагууд (хувь)



Цахим хуудасгүй төрийн өмчит хуулийн этгээдүүдийн дийлэнхи хувийг орон нутагт байршилтай төрийн өмчит хувьцаат компаниуд эзэлж байна.

Харин шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллээ нийтэлдэг тусгай цэс цахим хуудсанд байгаа эсэх нь дараах байдалтай байна.

Дүрс 29. Өөрийн цахим хуудсанд ШД-ны тусгай цэстэй байдал (хувь)



Өөрийн цахим хуудастай 50-н байгууллагын 32 нь бие даасан шилэн дансны цэс үүсгэн, үүгээр мэдээллээ олон нийтэд түгээж байгаа бол цахим хуудастай ч шилэн дансны тусгай цэс байхгүй 18-н төрийн өмчит хуулийн этгээд байна. Үүнээс үзэхэд шилэн дансны тухай хуулийн заалт ёсоор уг хуультай холбогдох мэдээллээ өөрийн цахим

хуудсанд тусгай цэс үүсгэн мэдээллэх байдал төрийн өмчит хуулийн этгээдүүд дунд хангалтгүй байдалтай хэрэгжиж байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд (<http://shilendans.gov.mn/>) өөрийн байгууллагыг төлөөлсөн цэстэй байх байдал бүх байгууллагуудын хувьд биелэлттэй байна. Гэвч тухайн шилэн дансны нэгдсэн цахим хуудсан дахь цэсэндээ мэдээлэл оруулсан байдал харилцан адилгүй байна.

ШДНЦХ-нд ямар нэгэн мэдээлэл оруулсан болон огт мэдээлэл оруулагүй байгууллагуудыг хувьчлан харуулбал дараах байдалтай байна.

Дүрс 30. ШДНЦХ-нд мэдээлэл оруулсан байдал (хувь)



Нийт судалгаанд хамрагдсан 83-н төрийн өмчит хуулийн этгээдүүдээс 9 нь тухайн цахим хуудсанд ямарч төрлийн мэдээллийг жилийн хугацаанд оруулаагүй байдал харагдаж байна.

2.6.2 Мэдээллийн холбогдолтой байдал

Мэдээллийн холбогдолтой байдал гэдэгт “шилэн дансны тухай хуулийн дагуу цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэх мэдээлэл”-ийн дагуу мэдээллүүдээ нийтэлсэн байдлыг судалж үзсэн.

Төрийн өмчит хуулийн этгээдүүдийн хувьд цахим хуудсаар дамжуулан “төсөв гүйцэтгэл”, “хөрөнгө оруулалт”, тендер, худалдан авалт”, “үнэт цаас”, “байгууллага”

гэсэн 5-н төрлийн бүлэг утгатай мэдээллийг цахим хуудсаар дамжуулан иргэдэд хүргэх ёстой байдаг. Бид энэхүү судалгаандаа төсөв гүйцэтгэл, тендер худалдан авалттай холбоотой мэдээллийн холбогдолтой байдлыг шалгаж үзсэн болно.



Нийт үнэлгээнд хамрагдсан төрийн өмчит хуулийн этгээдүүдийн 60-аас дээш хувь нь тухайн жилийн төсөв, 5-н сая төгрөгөөс дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлээ олон нийтэд мэдээлж байгаа бол төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт, ХАА-нд хийсэн аудитын дүгнэлт, ХАА-ны төлөвлөгөө зэргээ маш бага хувьтай цахим хуудсанд нийтэлж байна.

2.6.3 Мэдээллийн найдвартай байдал ба цаг үеийн байдал

Шилэн дансны тухай хуульд холбогдох мэдээллийн найдвартай байдлыг үнэлэхдээ тухайн оруулсан мэдээллийн эх сурвалж байгаа эсэхийг мөн тухайн цаг үедээ буюу мэдээллийг ашиглаж болохуйц цаг хугацаанд оруулсан эсэхээр хэмжсэн болно.

Төрийн өмчит хуулийн этгээдүүд өөрийн цахим хуудсанд эсвэл ШДНЦХ-нд мэдээлэл оруулсан тохиолдолд эх сурвалжаа, хугацаагаа тавих байдал харьцангуй сайн байгааг дараах дүрсээс харж болохоор байна.




Мэдээллийг оруулсан тохиолдолд эх сурвалжийг тавьсан байдал 100 хувь тохиолдож байгаа бол ашиглагдахуйц хугацаанд нийтэлж байгаа байдал бага зэрэг муу явагдаж байгааг харж болохоор байна.

2.6.4 Мэдээллийн хэрэглэхэд хялбар байдал

Мэдээллийн хэрэглэхэд хялбар байдал гэсэн хэсэгт бид шилэн дансны тухай хуультай холбогдох мэдээллүүдийн татаж авах, ашиглах боломжтой эсэх, хэвлэх боломжтой эсэх гэсэн шалгууруудаар үнэлж үзсэн.

Байгууллагуудын өөрийн цахим хуудсандаа болон ШДНЦХ-нд оруулж буй мэдээллийн хэрэглэхэд хялбар байдал дараа байдалтай байна.



Цахим хуудсан дахь мэдээллийг татаж авах боломжтой байдал 46 хувьтай байгаа бол цахим хуудсаас хэвлэх боломжтой байдал 35 хувьтай байна.

ХАВСРАЛТ 1. ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД

Төрийн байгууллын “ил тод” болон “нээлттэй байдал” гэдэг нь ялгаатай ойлголтууд бөгөөд уг мониторинг эхний ойлголтод суурилна. Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа. Хөгжлийн Байгууллагын тодорхойлсноор ил тод байдал бол сайн засаглалын тулгын гурван чулуу болох *хариуцан тайлагнах байдал* (accountability); ил тод байдал (transparency). *Нээлттэй байдал* (openness)-ын нэг бүрэлдэхүүн хэсэг юм (OECD, 2011). Харин НҮБ-ын Ази. Номхон Далайн Эдийн засаг Нийгмийн Комисс ил тод байдлыг сайн засаглалыг илэрхийлэх найман шинж байдлын нэг гэж үзээд энэ нь нээлттэй байдал гэх ойлголтоос тусдаа болохыг тэмдэглэжээ. Мөн бидний судалгаандаа гол мөрдлөг болгон ашиглаж буй 143 дугаар тогтоол “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт” нь нээлттэй байдлыг гэхээс илүүтэй ил тод байдлыг онцлон авч үзсэн байна. Тиймээс эдгээрээс үндэслэн мониторинг нь “ил тод” байдлыг онцлон шинжилсэн.

Ил тод байдал: “Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл нь найдвартай, холбогдолтой, цаг үеэс хоцролгүй олон нийтэд хүрч байгааг хэлнэ” (OECD, 2011). Харин НҮБ-ын Ази Номхон Далайн Эдийн Засаг Нийгмийн комисс “Ил тод байдал гэдэг нь төрөөс гаргаж буй шийдвэр, үйл ажиллагааны талаарх мэдээлэл нь уг шийдвэрийн нөлөөлж буй хэнд ч чөлөөтэй, хүртээмжтэй байхыг хэлнэ” гэжээ (UNESCAP, 2011).

Цахим үйлчилгээ: Төрийн байгууллагаас иргэдэд үзүүлдэг үндсэн үйлчилгээг цахим хуудсаар дамжуулан үзүүлэх

Цахим оролцоо: Төрийн байгууллагын үйл ажиллагаа болон гаргаж буй хууль, тогтоол.

Төрийн байгууллагын цахим хуудас: Төрийн байгууллагаас өөрсдийн шийдвэр, үйл ажиллагаа, бүтээгдэхүүн болон иргэдэд шаардлагатай, хуулиар хориогүй бусад мэдээллийн үйлчилгээ үзүүлэх, төрийн үйлчилгээг сүлжээгээр дамжуулан иргэдэд хүргэхэд зориулсан вэб технологид суурилсан мэдээллийн систем

Байгууллагын бүтэц, зохион байгуулалт: Тухайн байгууллага үйл ажиллагаагаа хэвийн хэмжээнд явуулахад баримтлах хууль, эрхзүйн актаар баталгаажуулсан албан ёсны бүтэц, зохион байгуулалт

Байгууллагын үйл ажиллагаа: Тухайн байгууллагын өдөр тутмын болон иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн бүхий л үйл ажиллагаа

Хүний нөөцийн бодлогын ил тод байдал: Төрийн байгууллагын албан хаагчийн ажлын зар болон сонгож авах шалгуур үзүүлэлт, түүнтэй холбоотой баримт бичгийг иргэд олж авах боломжоор хангасан байдал

Төсөв, санхүүгийн ил тод байдал: УИХ-аас батлан тухайн төрийн байгууллагад зарцуулах эрх олгосон төсөв, түүний зарцуулалт, төсвийн төсөл, мөн эдгээр баримт бичигт хийгдсэн аудит болон бусад хяналтын тайланг иргэдэд ойлгомжтой байдлаар түгээх, түүнийг ашиглах боломж олгосон байдал

Худалдан авах ажиллагааны ил тод байдал: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хийгдэж буй бүхий л худалдан авалтын урилга болон холбогдох баримт бичгүүдийг ашиглахад хялбар байдлаар иргэдэд түгээх, түүнийг ашиглах боломж олгосон байдал.

ХАВСРАЛТ 2. АРГА ЗҮЙН ТАЙЛБАР

Хүснэгт 6. Мониторингийн шалгуур үзүүлэлтүүд

Шалгуур үзүүлэлт	Тодорхойлолт	Хэмжүүр	Хүрээ
Мэдээллийн холбогдолтой байдал (Relevance)	Тухайн цахим хуудас нь МИТББМАЭТХ болон ШДТХ-д заасан мэдээллүүдийг хэрэглэгчдэд өгч байгаа эсэх	Мэдээлэл цогц бүрэн байгаа эсэх	Үйл ажиллагаа
			Хүний нөөц
			Төсөв. санхүү байдал
			Худалдан авах ажиллагаа
Мэдээллийн найдвартай байдал (Reliability)	Тухайн цахим хуудас дахь мэдээлэл хэрэглэгчдэд итгэл төрүүлэхүйц байгаа эсэх	Мэдээллийн эх сурвалж тодорхой байгаа эсэх	Хүний нөөц
			Төсөв. санхүү байдал
			Худалдан авах ажиллагаа
Мэдээллийн цаг үеийн байдал (Timeliness)	Цахим хуудас цаг үеийн. ач холбогдлоо алдаагүй мэдээлэл тавьсан эсэх	Тухайн мэдээллийг оруулсан хугацаа тодорхой эсэх	Хүний нөөц
			Төсөв. санхүү байдал
		Тухайн мэдээлэл хэрэглэгчдэд зориулж боломжит хугацаанд нийтлэгдэж байгаа эсэх	Худалдан авах ажиллагаа
			Хүний нөөц
		Тухайн мэдээлэл тогтмол шинэчлэгддэг эсэх	Төсөв. санхүү байдал
			Худалдан авах ажиллагаа
Цахим хуудасны хүртээмжтэй байдал (Accessibility)	Цахим хуудас нь хэрэглэгчид төрийн байгууллагаас шууд хандан мэдээлэл авах боломж олгосон. мөн хоёр талын оролцоог хангасан эсэх	Асуулт хариултын булан байгаа эсэх	
		Хэлэлцүүлгийн булан байгаа эсэх	
		Холбоотой байгууллагын холбоос линк байгаа эсэх	
		Тогтмол асуудаг асуултуудын хариулт байгаа эсэх (FAQ)	
		Хэлний сонголт байгаа эсэх	
Цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдал (Usability)	Хэрэглэгчдэд тухайн цахим хуудсын бүтэц, дизайн, үзэмж зэрэг нь ашиглахад хялбар байгаа эсэх	Цахим хуудасны үсгийн хэмжээ тохиромжтой. харагдахуйц байгаа эсэх	
		Цахим хуудасны цэс ойлгомжтой эсэх	
		Цахим хуудас өнгөний зохицолтой эсэх	
		Цахим хуудасны бүх мэдээлэл нь нэгэн жигд сонгосон хэл дээр гарч байгаа эсэх	
		Цахим хуудасны мэдээлэл уншиж үзэхэд шаардлагатай программыг татаж авах боломжтой байгаа эсэх	
		Дурын браузерээс тухайн цахим хуудас руу орох боломж байгаа эсэх	
		Цахим хуудаст алдаа гарч байгаа тохиолдолд шийдэх арга замыг зааж өгч байгаа эсэх	
		Цахим хуудаст хайлтын цэс байгаа эсэх	
		Цахим хуудаст цахим шуудангийн хаяг байгаа эсэх	
		Цахим хуудаснаас хэвлэх боломж байгаа эсэх	
		Цахим хуудаст файлыг хадгалах боломж байгаа эсэх	
Цахим хуудаснаас мэдээллийг бусдад илгээх боломж байгаа эсэх			

Хүснэгт 7. Тухайн шалгуурыг ямар хэмжээнд хангаж байгааг үнэлэх үнэлгээ

Хувь	Холбогдолтой байдал	Найдвартай байдал	Цаг үеийн байдал	Хүртээмжтэй байдал	Хэрэглэхэд хялбар байдал	Ил тод байдал
81-100	Бүрэн холбогдолтой	Мэдээлэл бүрэн найдвартай	Мэдээлэл тогтмол шинэчлэгддэг	Бүрэн хүртээмжтэй	Хэрэглэхэд маш хялбар	Бүрэн ил тод
61-80	Холбогдолтой	Найдвартай	Ихэнхи мэдээлэл шинэчлэгддэг	Хүртээмжтэй	Хэрэглэхэд боломжтой	Ил тод
41-60	Зарим талаар холбогдолтой	Зарим талаар найдвартай	Зарим мэдээлэл шинэчлэгддэг	Зарим талаар хүртээмжтэй	Хэрэглэхэд төвөгтэй	Зарим талаар ил тод
0-40	Мэдээлэл огт байхгүй эсвэл холбогдолгүй	Найдваргүй	Хоцрогдсон мэдээлэл	Хүртээмжгүй	Хэрэглэхэд маш төвөгтэй	Хаалттай

Хүснэгт 8. 2015 оны мониторингийн аргазүйд нэмж оруулсан шалгуур үзүүлэлтүүд

Шалгуур үзүүлэлтийн хүрээ	Нэмсэн үзүүлэлт	Эх сурвалж
Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал	Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт	МИТББМАЭТХ-ийн 7.1.3-р зүйл
	Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, заавар	МИТББМАЭТХ-ийн 7.1.4-р зүйл
Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	Албан хаагчийн ёс зүйн дүрэм	МИТББМАЭТХ-ийн 8.1.3-р зүйл
	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам	МИТББМАЭТХ-ийн 8.1.4-р зүйл
	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж байга	МИТББМАЭТХ-ийн 8.1.5-р зүйл
Төсөв, санхүүгийн ил тод байдал	Шилэн дансны тусгай цэс байгаа эсэх	ШДТХ-ийн 5.1.1-р зүйл
	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	ШДТХ-ийн 6.1.1-р зүйл
	Аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл	ШДТХ-ийн 6.1.5-р зүйл
	Төсвийн хэмнэлт хэтрэлт түүний шалтгааны тайлбар	ШДТХ-ийн 6.1.5-р зүйл
Худалдан авах ажиллагааны ил тод байдал	Тендерийн баримт бичиг	ШДТХ-ийн 6.4.3-р зүйл
	Тендер шалгаруулалт явуулах журам	ШДТХ-ийн 6.4.3-р зүйл
	Тендерт оролцохыг сонирхогчид тавигдах шалгуур үзүүлэлт	ШДТХ-ийн 6.4.3-р зүйл
	Цалингийн зардлаас бусад 5 сая.төг-с дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга	ШДТХ-ийн 6.4.5-р зүйл
	Мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр/бонд, зээл, өрийн бичиг гэх мэт/	ШДТХ-ийн 6.4.8-р зүйл

ХАВСРАЛТ 3. СУДАЛГААНД ХАМРУУЛСАН ЦАХИМ ХУУДСУУД**Монгол Улсын яам**

1.	Байгаль орчин. ногоон хөгжил. аялал жуулчлалын яам	http://www.mne.mn/
2.	Гадаад хэргийн яам	http://www.mfa.gov.mn/
3.	Сангийн яам	http://www.mof.gov.mn/
4.	Хууль зүйн яам	http://www.moj.gov.mn/
5.	Аж үйлдвэрийн яам	
6.	Барилга. хот байгуулалтын яам	http://www.mcud.gov.mn/
7.	Батлан хамгаалах яам	http://www.mod.gov.mn/
8.	Боловсрол. соёл. шинжлэх ухааны яам	http://www.meds.gov.mn/
9.	Зам. тээврийн яам	http://www.mrt.gov.mn/
10.	Уул уурхайн яам	http://www.mm.gov.mn/
11.	Хүнс. Хөдөө Аж ахуйн яам	http://www.mofa.gov.mn/
12.	Хөдөлмөрийн яам	http://www.mol.gov.mn/
13.	Хүн амын хөгжил. нийгмийн хамгааллын яам	http://www.khun.gov.mn/
14.	Эрчим хүчний яам	http://www.energy.gov.mn/
15.	Эрүүл мэнд. спортын яам	http://www.moh.mn/

2.1 Хэрэгжүүлэгч агентлаг

1.	Хөрөнгө оруулалтын газар	http://www.investmongolia.com/
2.	Худалдан авах ажиллагааны газар	http://www.e-tender.mn/
3.	Оюуны өмчийн газар	http://ipom.mn/
4.	Цаг уур. орчны шинжилгээний газар	http://www.namem.mn/
5.	Гаалийн ерөнхий газар	http://www.customs.gov.mn/
6.	Татварын ерөнхий газар	http://mta.mn/
7.	Улсын бүртгэлийн ерөнхий газар	https://burtgel.gov.mn/
8.	Архивын ерөнхий газар	http://www.archives.gov.mn/
9.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	http://cd.gov.mn/
10.	Иргэний харьяалал. шилжилт хөдөлгөөний ерөнхий газар	http://www.immigration.gov.mn/
11.	Тахарын ерөнхий газар	http://www.takhar.gov.mn/
12.	Газрын харилцаа. геодези. зураг зүйн газар	http://www.gazar.gov.mn/
13.	Иргэний нисэхийн ерөнхий газар	http://www.mcaa.gov.mn/
14.	Ашигт малтмалын газар	http://www.mram.gov.mn/
15.	Газрын тосны газар	http://www.pam.gov.mn/
16.	Мал эмнэлэг. үржлийн газар	http://dvab.gov.mn/
17.	Нийгмийн даатгалын ерөнхий газар	http://www.ndaatgal.mn/
18.	Нийгмийн халамж. үйлчилгээний ерөнхий газар	http://www.halamj.gov.mn/
19.	Хүүхдийн төлөө үндэсний газар	http://www.nac.gov.mn/

2.2 Тохируулагч агентлаг

1.	Тагнуулын ерөнхий газар	http://www.gia.gov.mn/
2.	Төрийн өмчийн хороо	http://www.spc.gov.mn/
3.	Мэдээллийн технологи. шуудан.харилцаа холбооны газар	http://www.itpta.gov.mn/
4.	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	http://inspection.gov.mn/
5.	Онцгой байдлын ерөнхий газар	http://nema.gov.mn/
6.	Шударга өрсөлдөөн. хэрэглэгчийн төлөө газар	http://www.afccp.gov.mn/
7.	Стандартчилал. хэмжил зүйн газар	http://www.masm.gov.mn/
8.	Цагдаагийн ерөнхий газар	http://www.police.gov.mn/

9.	Хил хамгаалах ерөнхий газар	http://bpo.gov.mn/
10.	Зэвсэгт хүчний жанжин штаб	http://gsmaf.gov.mn/

Парламентийн харъяа байгууллагууд

1.	Төрийн Албаны Зөвлөл	http://csc.gov.mn
2.	Авлигатай Тэмцэх Газар	http://www.iaac.mn/
3.	Санхүүгийн Зохицуулах Хороо	http://www.frc.mn/
4.	Сонгуулийн Ерөнхий Хороо	www.gec.gov.mn
5.	Хүний Эрхийн Үндэсний Комисс	www.mn-nhrc.org
6.	Үндэсний Аудитын Газар	www.mnao.mn
7.	Үндэсний Статистикийн Хороо	www.nso.mn/
8.	Монгол Банк	www.mongolbank.mn
9.	Монгол Улсын Их Хурал	www.parliament.mn

Улаанбаатарын дүүргүүдийн ЗДТГ

1.	Нийслэл Улаанбаатар хот	http://www.ulaanbaatar.mn
2.	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	http://ubservice.ub.gov.mn/
3.	Баянгол дүүрэг	http://www.bgd.mn
4.	Багахангай дүүрэг	http://www.bagakhangai.ub.gov.mn
5.	Баянзүрх дүүрэг	http://www.bzd.ub.gov.mn/
6.	Багануур дүүрэг	http://bnd.ub.gov.mn/
7.	Чингэлтэй дүүрэг	www.chingeltei.gov.mn
8.	Сүхбаатар дүүрэг	www.sbd.ub.gov.mn
9.	Сонгинохайрхан дүүрэг	www.shd.mn/
10.	Хан-Уул дүүрэг	www.khanuul.mn
11.	Налайх дүүрэг	www.nad.ub.gov.mn

